



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/86

Арвайхээр

«Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн»  
орон тооны бус зөвлөл шинэчлэн байгуулах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь заалт, Хөдөлмөрийн сайдын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах тухай” 2015 оны а/114 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийг сумын хэмжээнд дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга: Сумын Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Мал эмнэлгийн тасгийн дарга


Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Багийн Засаг даргын ажлын албаны ахлагч

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ахлах мэргэжилтэн

2. Зөвлөлийн үйл ажиллагааг тогтмол, үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Зөвлөлийн дарга (Ц.Хоролсүрэн), зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.ПҮРЭВДОРЖ